

2012.10 Дугаар 4

Follow Up төслийн санал

Project E-News

【Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл】

Төсөл хариуцсан ажилтан Г. Содгэрэл

Volunteer E-News

【Нийслэлийн Хөдөлмөрийн Газарт ажиллаж буй ахмад сайн дурын гишүүн Баба Сэйичи】

Сайн дурынхныг хариуцсан ажилтан Ц. Орхонтуяа

Сургалт төгсөгчийн булан

Сургалт төгсөгч Л.Лхатаасүрэн

Бусад

[Сургалт төгсөгчдийн сургалтын дараах судалгааны тайлан \(англи хэл дээрх хураангуй\)](#)

[Жайка Монгол дахь төлөөлөгчийн газрын шинэчилсэн танилцуулга](#)

Бэлтгэсэн : Түвшин-Од

Жайка Монгол дахь төлөөлөгчийн газар
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай3,
Улаанбаатар
Утас: 976-11-325939, 312393
Факс: 976-11-310845
E-mail: mg_oso_rep@jica.go.jp
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

Сайн байцгаана уу эрхэм төгсөгчдөө!

Та бүхэнд зориулан гаргадаг цахим сонингийн дараагийн дугаарыг хүргэж байна.

Энэ удаад Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл болон Монголд ажиллаж буй Ахмад сайн дурын гишүүний үйл ажиллагааны тухай танилцуулахаар бэлтгэлээ. Сургалт төгсөгчийн сургалтын дараах үйл ажиллагааны шилдэг жишээ болгон Ус Сувгийн Удирдах Газрын ажилтан Лхатаасүрэнгийн талаар мөн танилцуулж байна. Энэ нийтлэл нь түрүүчийн дугаар дээр дурьдаж байсан Жайка-ийн олон орны сургалт төгсөгчдийн амжилтын талаарх танилцуулгад орсон нийтлэл ба Япон хэлнээс орчуулан та бүхэнд хүргэж байгаа юм.

Мөн өмнөх дугаар дээр дурьдагдаж байсан, сургалт төгсөгчдийн сургалтын дараах судалгааны тайлангийн англи хэл дээрх товчлолыг Жайка-ийн вэбсайтад байршуулсан байна. Хажуу талын линкээр орж сонирхоорой. Жайка Монгол дахь Төлөөлөгчийн Газар мөн энэ судалгааны үеэр ярилцлага өгсөн 12 сургалт төгсөгчдийн нийтлэлийг нэгтгэн, сургалт төгсөгчдийн сургалтын дараах амжилтын талаарх монгол хэл дээрх танилцуулга гаргахаар төлөвлөж байгаа ба бэлэн болонгуут та бүхэнд танилцуулах болно.

Энэ жилийн 4 сард Японы Монголд үзүүлэх зээл, тусламжийн чиглэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан Жайка-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын төслүүдийн танилцуулга материал бас шинэчлэгдсэн ба зүүн талын линкээр орж, одоо хэрэгжиж буй техникийн хамтын ажиллагаа, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, өвсний үндэсийн хөтөлбөрүүдийн талаар сонирхоно уу.

Эцэст нь та бүхэнд зарлал хүргэе.

Өнгөрсөн жилтэй адилаар Follow Up төслийн санал авч эхэллээ. Сургалтын үеэр бичиж байсан “үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлт болон сургалтын үр дүнд суурилсан таны цаашдын үйл ажиллагааг дэмжихийн тулд, сургалт семинар зохион байгуулах болон гарын авлага бэлтгэн гаргах зэргээр сургалтын үр дүнг дээшлүүлэхэд Жайка-ийн зүгээс дэмжлэг шаардлагатай бол хажуугийн мэйл хаягаар холбоо барина уу. Төсвийн хувьд хязгаартай тул бүх саналыг хүлээж авах боломжгүй боловч, ирүүлсэн төслийн саналын дагуу судалж сонгоно. 2002 оноос хойших сургалтанд оролцсон төгсөгч байх, 2012 оны 2 сар хүртэл хэрэгжих гэсэн 2 нөхцөлтэй.

Эцсийн хугацаа : 12 сарын 3 өдөр (Даваа гариг)



Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл

Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв нь Монголын зах зээлийн эдийн засгийн шилжилтэнд хувь нэмэр оруулах, Монгол Япон 2 улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Японы туслалцааны бодит нүүр царай” болж буцалтгүй тусламжийн хүрээнд баригдсан билээ. Түүнчлэн бизнесийн, Япон хэлний, Хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагааг голчлон Техникийн хамтын ажиллагааны төсөл болох “Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн I үе шатыг 2002.01-2007.01 хооронд, II үе шатыг 2012.01-2012.01 хооронд хэрэгжүүлж, зах зээлийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх болон Япон хэлний боловсролыг дэмжиж, хамтран ажиллах түшиц газар нь болж, үр дүнтэй дэмжлэг үзүүлж ирсэн билээ.

Монголын эдийн засгийн хурдацтай хөгжлийн өгөөж нь ядуу давхаргад бүрэн хүрч чадахгүй байгаа тул ХАА, уул уурхайн салбараас бусад салбарыг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх нь нэн чухал зорилт болж байна. Сүүлийн 10 жилийн турш бизнесийн төрөл бүрийн сургалтанд 5300 гаруй ЖДҮ эрхлэгч болон холбогдох ажилтнуудыг хамруулж, бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, менежментийг сайжруулах дэмжлэг үзүүлж ирлээ.

Түүнчлэн Монгол улсын эдийн засгийн өсөлттэй уялдаад аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлж, бизнесийн мэдлэг, ноу-хауг илүү өндөр түвшинд хүргэх хэрэгцээ шаардлагатай болж байна. Үүний зэрэгцээ ЖДҮ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төр захиргааны хүний нөөцийг хөгжүүлэх шаардлагатай тул 2012 оны нэгдүгээр сараас бизнесийн хүний нөөцийг

хөгжүүлэхэд голлон анхаарсан “пост 2-р үе шатны төсөл” хэрэгжиж эхлээд байна.

Уг төслийн хүрээнд дараах чиглэлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Үндсэн сургалт

“ЖДҮГ-ын менежмент үнэлгээ, шинжилгээ” сэдвээр ЖДҮ эрхлэгчдэд зориулж дараах сургалтыг хэрэгжүүлнэ.

- 1/ Менежментийн стратеги, 2/ Маркетинг, 3/ Үйлдвэрлэлийн удирдлага (үйлдвэрийн салбар)
- 4/ Дэлгүүр болон үйлчилгээний газрын зохион байгуулалт (үйлчилгээний салбар)
- 5/ Санхүүгийн удирдлага, 6/ Хүний нөөцийн удирдлага

2. Тусгай ба Ахисан түвшний сургалт

● Тусгай сургалт

- 1/ Шинээр бизнес эрхлэгчдийг дэмжих сургалт
- 2/ Төслийн удирдлага
- 3/ Удирдлагын нягтлан бодох бүртгэл
- 4/ Харилцааны ур чадвар ба идэвхижүүлэлт

● Ахисан төвшний сургалт

- 1/ Шийдвэр гаргалт ба асуудлыг шийдвэрлэх нь
- 2/ Манлайлал болон багаар ажиллах
- 3/ Байгууллага болон хүний нөөцийн үр дүнгийн удирдлага

3. Аж ахуйн нэгжийг хөгжүүлэх

- 1/ Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх
- 2/ Менежментийн удирдлага
- 3/ Ажлын байран дахь сургалт

4. Үндэсний сургагч багш бэлтгэх хөтөлбөр

5. Төрийн албан хаагчдад зориулсан сургалт

6. Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих

* Дээрхи сургалтыг Япон мэргэжилтэн болон үндэсний сургагч багш заана.



Volunteer E-News

Энэ удаагийн дугаарт сүүлийн үеийн сайн дурын гишүүдийн томилгооны тухай мэдээлэл болон Нийслэлийн Хөдөлмөрийн Газарт ажиллаж буй ахмад сайн дурын гишүүн Баба Сэйчигийн гаргасан нэгэн номны талаар танилцуулахаар бэлтгэлээ.

Одоогийн байдлаар нийт 55 сайн дурын гишүүн Монгол улсад ажиллаж байна. Жайка нь жилд 2 удаа сайн дурын гишүүний сонгон шалгаруулалтыг Японд зохион байгуулж, жилд 4 удаа дэлхийн олон улсуудад томилдог. Үүний дагуу Монгол улсад ч мөн адил энэ 9 сарын 20-нд 8 сайн дурын гишүүн буцаж, 9 сарын 25-нд 8 сайн дурын гишүүн шинээр томилогдон ирсэн.

	Сайн дурын гишүүний нэрс	Мэргэжил	Томилолт ын хугацаа	Томилогдсон газар
1	Хата Мисато	Сувилагч	2012.10.1-2014.9.30	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг
2	Нишияма Ёко	Сувилагч		Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газар
3	Накамото Юки	Эрүүл ахуйч		Төв аймгийн нэгдсэн эмнэлэг
4	Танно Хироми			Булган аймгийн хүүхдийн төлөө газар
5	Хорикава Юкино	Биеийн тамир		Орхон аймгийн боловсрол соёлын газар
6	Мори Кацүяа	Сагсан бөмбөг		Сэлэнгэ аймгийн спортын бүрэн дунд сургууль
7	Обиканэ Ясүо	Механик инженер		ШУТИС, Механик инженерийн сургууль
8	Като Хидэо	Хүнсний хяналт шалгалт		Мэргэжлийн хяналтын төв лаборатори

❖ Ахмад сайн дурын гишүүн Баба Сэйчигийн үйл ажиллагааны нэг хэсгийн танилцуулга.

Баба Сэйичи ахмад сайн дурын гишүүн нь 2011.3~2013.3сар хүртэл Нийслэлийн Хөдөлмөрийн Газарт хөдөлмөр зуучлалын мэргэжлээр томилогдон ажиллаж байна. Баба Сэйичи нь ажиллах хугацаандаа Монголын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлыг судлан үзсэний үндсэн

дээр Монголд танил талаараа ажилд орох явдал их байдаг бөгөөд чөлөөтэй, нээлттэй хөдөлмөрийн зах зээл хараахан хөгжөөгүй байгааг олж мэдрэн, Японд шинэ ажилтан авахад хэрэглэдэг “Суурь мэдлэгийн тест”-ийг Монголд нэвтрүүлэхээр зорьж ажиллаж эхэлсэн. Ингэснээр, чөлөөтэй нээлттэй хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоо бий болох нэгэн хөшүүрэг болоосой гэсэн сэтгэлээр “Суурь мэдлэгийн тест буюу SPI” номыг орчуулан, хэвлүүлжээ.

Одоо түүний ажиллаж буй Нийслэлийн хөдөлмөрийн газар нь шинээр сургууль төгсөгчдөд ажил зуучлах үйл ажиллагаандаа ихээхэн анхаарал хандуулж байна. Уг “Суурь мэдлэгийн тест” нь Японы олон байгууллагуудын шинэ ажилтан сонгон шалгаруулахад хэрэглэдэг материалын нэг бөгөөд Монголын тухайд энэ төрлийн тест байдаггүй байсан. Нийслэлийн хөдөлмөрийн газарын үйлчилгээнд уг “Суурь мэдлэгийн тест”-ийг нэвтрүүлэн ирээдүйд Монголын хөдөлмөрийн зах зээл хөрвөх чадвартай болон, глобалчлагдах үед, шударга үнэлгээний системийн стандартын нэгэн материал болон, олон байгууллагад хэрэглэдэг болгохыг зорисон.

SPI гэдэг нь Synthetic Personality Inventory гэдэг үгийн товчлол бөгөөд, хувь хүнийг бүх талаас нь үнэлэх зорилготойгоор 1974 онд Японы Recruit компаний нээсэн тест юм. Уг тест нь “Ур чадварыг тодорхойлох тест”, “Зан чанарыг тодорхойлох тест” гэсэн 2 хэсэгтэй. Эхэндээ хэвлэл мэдээлэлийн байгууллагууд голчлон хэрэглэдэг байсан боловч өнөө үед маш олон байгууллагууд ажилд авах тестийн нэг болгон хэрэглэж байна.

SPI-н “Ур чадварыг тодорхойлох тест” нь ажил гүйцэтгэх ур чадварыг хэмжих “Simulation test” юм. Өөрөөр хэлбэл тодорхой нэг ажлыг даалгахад хэр “Зөв” арга хэмжээ авах, хэр “Хурд”-тай гүйцэтгэхийг тодорхойлох тест юм.

Энэ номыг орчуулж, хэвлүүлэх ажилд Жайкагийн төлөөлөгчийн газар, Нийслэлийн хөдөлмөрийн газар, Дулааны 4-р цахилгаан станц гэх мэт маш олон хувь хүн болон албан байгууллагын туслалцаа дэмжлэг орсоныг дурдахад таатай байна. Мөн уг “Суурь мэдлэгийн тест”-ийг Нийслэлийн хөдөлмөрийн газар болон Дулааны 4-р цахилгаан станц ажилтан шалгаруулж авахдаа хэрэглэхээр болоод байна.

Эцэст нь хэрэв та бүхэн энэ номыг сонирхож байвал Нийслэлийн хөдөлмөрийн газартай холбоо барих боломжтой бөгөөд өөрсдийн ажилдаа бүтээлчээр хэрэглэнэ хэмээн найдаж байна.

Сургалт төгсөгчийн булан



Зүүн гар талаас Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын санхүү бүртгэлийн хэлтсийн санхүүгийн шинжээч (2004 оны “Олон нийтэд хандсан сурталчилгааны төлөвлөлт” сургалтанд оролцогч)

*** Зургийн баруун талд Д.Туяа мөн Жайка-ийн сургалт төгсөгч**

Сүүлийн үед Монгол улс нь сумогийн амжилт, газар доорх баялагаараа Япон улсын анхаарлыг татаж байна. Монгол улс нь урд, хойт талаараа Хятад, Орос хоёр их гүрнээр хүрээлэгдсэн, газар нутгийн хэмжээгээрээ Япон орноос 4 дахин том, хүн ам нь Киото хоттой ойролцоо хоёр сая долоон зуун мянга орчим орон юм. Хүн амын дөрөвний нэг нь Улаанбаатар хотод амьдардаг ба тус хотод хүн амын хурдацтай өсөлт, аж үйлдвэрийн өсөлтийг дагаад замын түгжрэл, агаар хөрсний бохирдол, хог хаягдал, усан хангамжийн хүрэлцээгүй байдал зэрэг асуудлууд тулгамдаад байна.

Үүн дотроо амьдарлыг тэтгэгч усны асуудал. Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах газар нь ард түмнээ аюулгүй цэвэр усаар тогтвортой хангахын тулд хичээн ажиллаж байдаг ба тус газрын ажилтан Л.Лхамаасүрэн (зураг дээр зүүн гар талд), Д.Туяа (зураг дээр баруун гар талд) нар 2004, 2007 онд усан хангамжийг сайжруулах чиглэлийн Жайка-ийн сургалтанд оролцохоор Япон оронд зочилж байсан юм.

Лхамаасүрэн Японы усан хангамжийн үйл ажиллагааны менежментийн талаар олон зүйлийг сурсан бөгөөд түүнд хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн нь Ёкохама мужийн ус сувгийн музейг үзэж танилцсан явдал байлаа. Музейд бидний гэрийн цоргоор ус гарч ирэх хүртэлх үйл явц, усны аюулгүй байдал, усан хангамжийн технологи, түүхийн талаар хүмүүс ойлгоход амарханаар үзүүлсэн байв. Монголд үүнтэй адил байгууллага байдаггүй болохоор хүмүүс ямар их зардал, үйл явц, дамжлагаар ус бидний гар дээр хүрдэгийг сайн мэддэггүй. Ийм мэдлэг муутайгаас усыг замбараагүй хэрэглэдэг хүмүүс олон байгаа нь томоохон асуудал болж байна. Жайка-ийн сургалтаар ард иргэдэд чиглэсэн

сурталчилгааны талаар суралцсан Лхамаасүрэн нь Ус Сувгийн удирдах газрын зүгээс жирийн ард иргэддээ хандсан, усны үнэ цэнийн талаар зааж сургахад чиглэсэн ажил хийх нь чухал юм гэдгийг ойлгосон байна.

Эх орондоо ирсний дараа, тэрээр сургалтаар олж авсан зүйлээ мөн усны боловсролын чухалыг дарга нар болон хамтран ажиллагсаддаа тайлагнан таниулсан. Ингээд хамт олныхоо дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын хүүхэд багачуудад усны талаар боловсрол олгох үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Тодорхойлбол тэрээр алдартай зохиолчийн тусламжтайгаар усны талаарх жүжгийг найруулуулан тавьж, ойролцоогоор 60,000 гаруй нийслэлийн бага ангийн сурагчдад толилуулсан. Түүнчлэн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэмжлэгээр сурагчийн дэвтэрийн нүүр хуудсанд усаа хэмнэх тухай зураг тавих, Боловсролын хороотой хамтран дунд сургуулийн сурагчдын дунд “Ус чандмань эрдэнэ” зохион бичлэгийг уралдааныг зарлах гэх мэт ажлыг зохион байгуулсан байна. Хамгийн сүүлд тэрээр усны үнэ цэнийн талаарх телевизийн рекламьг хийх ажилдаа орсон бөгөөд удахгүй дэлгэцнээ гарна.

Түүнтэй адил Жайка-ийн сургалтанд явсан Туяа нь Японы Ус сувгийн газар нь бэлэг тэмдэг хүүхэлдэйн баатартай гэдгийг мэдсэн бөгөөд энэ нь хүмүүс ус сувгийн үйл ажиллагаатай илүү ойртох мөн Ус сувгийн удирдах газрын имижийг сайжруулахад ач холбогдолтой байдаг. Сургалтаа төгсөж, эх орондоо ирээд шууд л байгууллагынхаа бэлэг тэмдэг юу байх вэ гэдгийг бодож олсон ба одоо Ус сувгийн удирдах газраас гаргаж буй бүхий л ном, гарын авлага, материалуудын нүүр хуудсанд бэлгэ тэмдэг болох Дусалхуу гарсан байдаг. Лхамаасүрэн, Туяа хоёр дизайнеруудтай хамтран усны сэдвээр хүүхдэд зориулсан цуврал комик ном, томлоом зэргийг хийсэн ба Ус сувгийн удирдах газраар зочилсон хүүхдүүдэд үнэгүй тараагддаг болоод байна.

Энэ мэтээр Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын Жайка-ийн сургалт төгсөгчид маань Японд олж авсан шинэ санаан дээрээ тулгуурлаад усны үнэ цэнийн талаарх боловсролыг олгох үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Энэ үйл ажиллагаа нь цаашид нь улам илүү өргөжих болтугай гэж хүсэн ерөөе.

